



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/509

Булган сум

### Барилгын засварын ажил ашиглалтад оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 49 дүгээр зүйлийн 49.1, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Рашаант сумын 320 хүүхдийн хүчин чадалтай хуучин сургууль, 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн өргөтгөл, спорт заал, гал тогоо, 80 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилгын дээврийн засварын гүйцэтгэл ажлын зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 07/2023 дугаартай дүгнэлтээр баталгаажсан тул 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс ашиглалтад оруулсугай.

2. Барилга байгууламжийн эзэмшигч ашиглагч нь тухайн барилга байгууламжийн үндсэн хөрөнгийг бүртгэлийн байгууллагад ажлын 10 хүртэл хоногт багтаан бүртгүүлж, барилга ашиглалтын дүрмийг чанд мөрдөж, барилгын хувийн хэрэг хөтлөх, барилгад дур мэдэн өөрчлөлт хийх зэрэг ашиглалтын горимыг зөрчихгүй ашиглахыг барилгын ашиглагч, эзэмшигч, өмчлөгч Рашаант сумын ерөнхий боловсролын сургууль (П.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү барилгын туршилт тохируулгын хугацааг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл, 14.6-д заасны дагуу 2027 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл тооцох ба энэ хугацаанд гүйцэтгэгчээс шалтгаалсан эвдрэл, гэмтлийг гүйцэтгэгч "Эрхэт чонос констракшн" ХХК-ийн хөрөнгөөр засуулах ажлыг захиалагч, ашиглагч нарт даалгасугай.

4. Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эх хувиар нь хүлээн авч архивын нэгж үүсгэн хадгалахыг Төрийн архивын тасаг (Д.Батсайхан)-т, барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэгснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын ашиглалтад оруулах комиссын дүнэлтийг үндэслэж, ажлын долоон өдрийн дотор ашиглалтын гэрчилгээ олгож, барилга ашиглалтын явцад тогтмол хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга техникийн хяналтын улсын байцаагч (Н.Очирхуяг)-т тус тус даалгасугай.

5. Барилгын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.2-д заасны дагуу барилгын ашиглалтын гэрчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагаас авахыг Рашаант ерөнхий боловсролын сургууль (П.Сийлэгмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6323010519